

ТАНИЛЦУУЛГА

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Сүүлийн хорин жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт нь “зуд” хэмээх үзэгдлийн нөлөөг улам ихэсгэж, түүнийг илүү давтамжтай, хүчтэй болгон үүний улмаас хамгийн эмзэг, ядуу малчид нэг л өвөлд бүх амьжиргаагаа алдах өндөр эрсдэлтэй нүүр тулж байна.

Монгол Улсад сүүлийн 80 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт эрчимжиж, агаарын дундаж температур 2.25 хэмээр нэмэгдсэн нь дэлхийн дунджаас хоёр дахин их, нийт нутаг дэвсгэрийн дөрөвний гурваас илүү хувь нь тодорхой хэмжээгээр цөлжилтөд өртөж, тал хувь нь эрчимтэй цөлжиж байгаа гэсэн ангилалд ороод байна. Уур амьсгалын суурь конвенцын 2018 онд гаргасан Монгол Улсын үндэсний гурав дахь тайланд 1990-ээд оноос хойш зудын давтамж улам нэмэгдсээр, 2080 он гэхэд 5-20%-аар ихсэх төлөвтэй байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлвөөс харахад цаг уурын цочир үзэгдэл илүү ойр давтамжтай, эрчтэй болохыг харуулж байна.

Иймд гамшиг нэгэнт болсны дараа авах арга хэмжээнээс илүү урьдчилан сэргийлэх нь үр дүнтэй байдаг талаар Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2018 онд хийсэн “Эрт сэрэмжлүүлгийн нөлөөллийн тайлан” судалгаанд гамшгийн үед эрт сэрэмжлүүлэх зорилгоор урьдчилж олгосон 1 ам.доллар нь 7 ам.доллар болон өсөж үр ашгаа өгдөг гэсэн тооцоолол гарсан байна.

Малчдыг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэгт тулгуурлан гамшигт нэрвэгдэхээс өмнө арга хэмжээ авах нь амин чухал бөгөөд ингэснээр амьжиргааг хамгаалах, цаашид тохиолдох цочролыг тэсвэрлэх эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, улсын төсөвт тулгарах дарамт, ачааллыг бууруулах боломжтой юм. Иймд уламжлалт мал аж ахуйг хамгаалах, малчин өрхийн эрсдэл тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх, өртөнг, эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн төрийн чиг үүргийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, малчин өрхийн гамшгийн эрсдэлийг бууруулах зориулалт бүхий санг үүсгэх хууль эрхзүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна. Энэ төрлийн санхүүжилтийн тогтолцоог улсын төсөвт нэмэлт дарамт үүсгэхгүйгээр бүрдүүлэх боломжтой бөгөөд хуулийн төсөлд “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-д заасан тусгай чиг үүрэг бүхий давхар даатгалын компанийн үйл ажиллагааны орлогоос уг сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно.

Мөн гамшигт үзэгдлийн давтамж, нөлөөлөл нь аймаг, сумдын газар зүйн байршил, цаг уурын нөхцлөөс хамааран харилцан адилгүй байдаг. Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг актуар тооцоололд үндэслэн тогтоох боломжтой хэдий ч зарим нутаг дэвсгэрт уг үзүүлэлт хэт өндөр тогтоогдох эрсдэлтэй. Энэ нь малчдын даатгалд хамрагдах сонирхлыг бууруулах, даатгалын үр шимийг хүртэх боломжийг хязгаарлах сөрөг нөлөөтэй.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд актуар тооцоололд үндэслэн дундаж малын хорогдлыг тооцож, нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг 5 хувь болгон бууруулсан. Үүний үр дүнд нөхөн төлбөрийг тогтмол давтамжтайгаар олгох нөхцөл

бүрдэх бөгөөд энэ нь малчдын даатгалын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог урт хугацаанд тогтвортой, өргөжин хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

--oOo--